



ДӨРВӨН УУЛ ХК

АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛ, АЯЛЛЫН БАРАА, БҮТЭЭГДХҮҮН,МОТОЦИКЛ,
ТОНОГ ТӨХӨӨРӨМЖИЙН ХУДАЛДАА, АГУУЛАХ, ТҮРЭЭС, ҮЙЛЧИЛГЭЭ

Дугаар:2019/03
Огноо :2019.03.21

Улаанбаатар хот

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫГ ЗАРЛАН ХУРАЛДУУЛАХ ТУХАЙ

Компанийн тухай хуулийн 60 дугаар зүйл, 62 дугаар зүйлийн 62.1.7, 62.1.9, 62.1.15 дахь заалт, 64 дугаар зүйл, 65 дугаар зүйлийн 65.3, 65.4 дэх заалт, 67 дугаар зүйл, Санхүүгийн зохицуулах хорооны 2018 оны 12 дугаар сарын 14-ны өдрийн 377 дүгээр тогтоолоор батлагдсан “Хувьцаат компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлын зар хүргэх, хяналт тавих журам”-ыг тус тус үндэслэн Төлөөлөн удирдах зөвлөлөөс **ТОГТООХ НЬ:**

1. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг 2019 оны 4-р сарын 30-ны 10 цагт Баянзүрх дүүрэг 8-р хороо Амгаланбаатар-32 өөрийн байранд хуралдуулсугай.
2. Тус ээлжит хурлаар дараах асуудлыг авч хэлэлцсүгэй.
 - 1.Компанийн 2018 оны үйл ажиллагааны талаарх болон санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-ийн дүгнэлтийг хэлэлцэх;
 - 2.Компанийн цаашид хэрэгжүүлэх үйл ажиллагааны бизнес төлөвлөгөөг батлах
 - 3.ТУЗ-ийн гишүүдийн бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах
 - 4.Бусад
3. Монгол улсын Санхүүгийн зохицуулах хорооны журмын дагуу “Хувьцаа эзэмшигчдийн хурлын мэдэгдэл”-ийг Хавсралт №1-ээр баталж, 2019 оны 03 дугаар сарын 22-ны өдрийн дотор багтаан Санхүүгийн зохицуулах хороо болон “Монголын хөрөнгийн бирж”-д хүргүүлэх, “Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын зар”-ыг Хавсралт №2-оор баталж 2019 оны 03 дугаар сарын 26-ны өдөр “Монголын хөрөнгийн бирж” болон өөрийн цахим хуудас, олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгслээр дамжуулан хувьцаа эзэмшигчдэд мэдээллэх, мөн уг зарыг 2019 оны 04 дүгээр сарын 10-ний өдөр анх мэдээлсэний дагуу дахин хурлын зар хүргэх, Бүртгэлийн өдрийг 4-р сарын 10-р , Саналын хуудас хүлээн авах өдрийг 2019 оны 4-р сарын 22-ны 17 цагаар тасалбар болгон тогтсугай.
4. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар хэлэлцэх асуудал, гарах шийдвэрийн төсөл, түүнтэй холбогдох баримт бичгийг "Хавсралт 6"-р батлаж, 2019 оны 03 дугаар сарын 31-ны дотор багтаан хувьцаа эзэмшигчдэд үйлчилж буй брокер диллерийн компанид хүргүүлсүгэй.
5. Хурлыг зохион байгуулах комиссын даргаар ТУЗ-ын дарга Ц.Одгэрэл, гишүүдэд Д.Одгэрэл, О.Цэрэннадмид нарыг томилсугай.
6. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын тооллогын комиссын даргаар А.Одмаа, гишүүнээр Б.Бадамгарав, А.Гантуяа нарыг томилсугай.
7. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын санал авах хуудсыг "Хавсралт 3, 4"-р баталсугай.
8. Хурлын дэгийг "Хавсралт 5"-р баталсугай.

ТУЗ-ийн ДАРГА

ТТА3949 ± 2095971

Ц.ОДГЭРЭЛ

“Дөрвөн-Уул”ХК. РД: 2095971. Баянзүрх дүүрэг 8-р хороо. Амгаланбаатар-32. Ш/Х-210348а-22.e-mail:
info.fourmountain@gmail.com

Утас: +976 70164545, 98980011, 98980012. Facebook.com/totalmotorsmongolia